



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/135

Мандалговь

Шинжилгээний төлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5, 29.1.6 "л" дэх заалт, Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 05/А12 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 01 сарын 12-ны өдрийн "Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг илрүүлэх шинжилгээг хийх, шинжилгээний жишиг үнэ тогтоох, орлогыг зарцуулах заавар батлах тухай" 05/А12 дугаар тушаалын дагуу орон нутагт иргэд, байгууллага аж ахуйн нэгжид төлбөртэй болон төлбөргүй коронавируст халдвар илрүүлэх шинжилгээ хийх журмыг хавсралтаар баталсугай.

2. Иргэд, байгууллага аж ахуйн нэгжид төлбөртэй болон төлбөргүй коронавируст халдвар илрүүлэх шинжилгээ хийх журмыг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Б.Алтантөгс)-д, шинжилгээний төлбөрийг төвлөрүүлэн, шинжилгээний урвалж, оношлуурын нөөцийг бүрдүүлж, худалдан авалтыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210350